

ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Холбоо барих утас: 1800-1646, 7575-1111 /1376/
Цахим шуудан: investornews@golomtbank.com



“ГОЛОМТ БАНК” ХК-ИЙН 2025 ОНЫ 2-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН НИЙТЛЭГДЛЭЭ

Монгол улс, Улаанбаатар хот - (2025.07.21) “Голомт Банк” ХК-ийн 2025 оны 2-р улирлын санхүүгийн тайлан нийтлэгдлээ.

2025 оны 1-р хагас жилд бизнесийн орчинд нөлөө үзүүлсэн гол макро-эдийн засгийн үзүүлэлтүүдийг дурдвал:

- Эдийн засаг 2025 оны 1-р улирал 2.4%-иар тэлэв. Эдийн засгийн өсөлтөд худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эерэгээр нөлөөллөө.
- Инфляц 2025 оны 6 сарын байдлаар 8.2% болж өмнөх сараас саарлаа. Монголбанкны 6 сарын мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүг 12%-ийн түвшинд хэвээр үлдээхээр шийдвэрлэлээ.
- Энэ оны эхний хагас жилд нийт экспорт 6.5 тэрбум ам.доллар, импорт 5.5 тэрбум гарч гадаад худалдааны тэнцэл ашигтай байна. Гадаад худалдаанд зэсийн экспортын орлого эерэг нөлөө үзүүлж байгаа бол нүүрсний үнийн бууралт сэргөөр нөлөөлж байна.
- Манай улсын гадаад валютын нөөц 5.2 тэрбум ам.доллар байгаа нь ханшийн тогтвортой байдалд голлон нөлөөлж байна.
- Олон улсын байгууллагуудын төсөөллөөр 2025 онд манай улсын эдийн засаг 6.3%-6.6%-иар өсөх хүлээлттэй байна. Тухайлбал, Монгол улсын 2025 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг Дэлхийн банкнаас 6.3%, ОУВС 6%, АХБ 6.6% байна гэж үзэж байна.

2025 оны 2-р улирлын онцлох үзүүлэлтүүдийг дурдвал:

- Банкны нийт актив өмнөх оны мөн үеэс 2.7 их наяд төгрөгөөр буюу 21.8 хувиар өсөж, 14.9 их наяд төгрөгт, харилцагчийн эх үүсвэр 22.5 хувиар өсөж, 8.8 их наяд төгрөгт хүрлээ.
- Банкны өөрийн хөрөнгө 25.8 хувиар өсөж 1.4 их наяд төгрөгт хүрч өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 14.9 хувьд хүрч сайжирлаа.
- Банк өмнөх оны мөн үеэс цэвэр зээлийн багцаа 23.3 хувиар тэлж 7.9 их наяд төгрөгт хүрэв. Зээлийн багцын тэнцвэртэй байдлыг ханган ажиллаж, нийт зээлийн 54 хувийг байгууллагын зээл, 46 хувийг иргэдийн зээл эзэлж байна. Активын чанарын удирдлагыг амжилттай хэрэгжүүлж, чанаргүй зээлийн харьцааг 0.5 хувиар бууруулж, 2.7 хувьд хүргэн сайжрууллаа.
- 2025 оны 2-р улирлын байдлаар 215.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд үйл ажиллагааны ашиг 235.5 тэрбум төгрөгт хүрлээ. Мөн өөрийн хөрөнгийн өгөөж 31.6 хувьд хүрлээ.
- Банк Монголбанк болон бусад гадаадын байгууллагуудаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.

Та [ЭНД](#) дарж Голомт банкны улирлын санхүүгийн тайлантай танилцах боломжтой.

Банкны тухай нэмэлт мэдээллийг даарах сувгуудаар авах боломжтой www.golomtbank.com/investor-relations

| X: [@golomtbank](#) | LinkedIn: www.linkedin.com/company/golomtbank

| YouTube: www.youtube.com/golomtbank

| Facebook: www.facebook.com/Golomtbank